



УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ  
ЭМНЭЛЭГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170

Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,

Цахим шуудан: contact@afccp.gov.mn,

Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.09.09 № 01/1542

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тендерийн баримт бичиг  
хянасан тухай**

Танай эмнэлгээс зарласан “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн соронзон резонанси томографийн аппарат /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ ЭМЯ/20240102047 дугаартай тендерийн баримт бичигт “Интер сайнс” ХХК, “Саммитмедикал сервис” ХХК-уудаас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянан үзлээ.

1.Тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д “Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “Шаардана”, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер мэргэжлээр төгссөн 3 ба түүнээс дээш инженертэй байх, /үйлдвэрлэгчийн сургалтад хамрагдсан инженертэй бол давуу тал болно/” гэж, техникийн тодорхойлолтын 18. Бусад хэсэгт “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер мэргэжлээр төгссөн 3 ба түүнээс дээш инженертэй байх” гэж тус тус заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана” гэж, мөн Эрүүл мэндийн сайдын 2006 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 404 тоот тушаалын хавсралтаар баталсан “Эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх байгууллагад тавигдах ерөнхий шаардлага” 5.2-д “Ханган нийлүүлэх байгууллагад 2-оос доошгүй мэргэжлийн хүн дараах ажлын байранд ажиллана. Үүнд: эмнэлгийн багаж, протез, тоног төхөөрөмжийн худалдааны инженер, Эмнэлгийн тоног төхөөрөмжийг засварлах, захиалга хүлээн авах, шалгах, суурилуулахад эмнэлгийн инженер тус тус ажиллана” гэж заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д болон техникийн тодорхойлолтын 18. Бусад хэсэгт барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн талаарх хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг заагаагүй байх тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

0003409

2. Тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д “Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “Шаардлагатай” Гэрээний мэдээлэл ирүүлэх жилийн тоо сүүлийн 2 жил, ...Уг хугацаанд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 20 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ доод тал нь 1 удаа” гэж тус тус заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална” гэж мөн Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/258 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн ТШЗ 18.1-д “Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: [“Шаардлагатай” эсхүл “Шаардлагагүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв шаардлагатай бол гэрээний мэдээлэл ирүүлэх жилийн тоо, нотлох баримт бичгийг тодорхой заах. [Жишээ: Уг хугацаанд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн [●] хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ доод тал нь [●] удаа. Захиалагч ижил төстэй барааг тухайлан зааж болно.]” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагын талаарх шалгуур үзүүлэлтийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/258 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу боловсруулсан байна.

3. Тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтын 10. Программ хангамж хэсэгт “Deep resolve Boost хийх боломжтой программтай байх эсхүл түүнтэй дүйцэхүйц байх, Deep Resolve Sharp хийх боломжтой программтай байх эсхүл түүнтэй дүйцэхүйц байх гэж тус тус заасан байна.


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т “Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно” гэж, 12.5-д “Техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох боломжгүй бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг дурдсаны үндсэн дээр зөвхөн тухайн бараанд холбогдуулан энэ хуулийн 12.4-т заасан шаардлага, нөхцөлийг тавьж болох бөгөөд энэ тохиолдолд “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтыг тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бүтээгдэхүүний онцлогт нийцүүлэн боловсруулсан байх бөгөөд техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох боломжгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендер шалгаруулалтын баримт бичигт болон үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд дурдаагүй байх тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.5 дахь хэсэгт заасныг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2 дахь заалтад заасны дагуу тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод холбогдох өөрчлөлт оруулж хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг даалгаж байна.

ДАРГА



Б.БИЛГҮҮН